

SPEECH BY MR. CH. SAIKHANBILEG, CHAIRMAN OF THE
INFORMATION AND COMMUNICATIONS TECHNOLOGY AUTHORITY
AT THE CONFERENCE OF FOREIGN INVESTORS

Distinguished guests and delegates.

Ladies and Gentlemen.

I would like to extend my sincere greetings to all the participants of this conference of foreign investors organized in the framework of activities of the 800 anniversary of the foundation of the Great Mongolian State.

I would like to draw your attention to the current situation of the development of information and communications sector of Mongolia, to the Government policy, strategy and legal environment for development of this sector.

The Government of Mongolia attaches primary importance to the development of information and communications sector which has the history of 800 years and is implementing many important objectives and measures considering it as a factor for acceleration of social and economic development.

The Government policy of development of information and communications sector is aimed at the policy of sustainable development of the sector, creation of favorable legal environment, reliable communications infrastructure, comprehensive development of human resources, development of multi-side consumption based on information and communications technology, enhancing the quality, access and scope of internet services, increase the number of consumers of internet and computer, increase the opportunity for information and education of citizens, students, support the business and private sector, partnership, cooperation, investment of the private sector, raising competitiveness of domestic program supply and production of information technology, creation of opportunity to access international market and develop it as a highly effective sector.

The Information and Communications Technology Authority was established in 2004 under the Prime Minister office to accelerate development of Information and Communications Technology sector and coordinate its activities. Important objectives to introduce the information and communications technology in all the social sectors have been reflected in the Government Action Program for 2004-2008.

Since its establishment, in the framework of relevant laws and such programs as “The Concept of Development of ICT until 2010”, “Master Plan for Development of Rural Communications until 2021”, “E-Mongolia”, the ICTA is implementing activities aimed at the sector liberalization, deepening competition, elaboration of the legal environment for development of the sector, development of the information, communications infrastructure, development of e-consumption, including e-Government, decrease of the digital divide, elaboration of the legal environment for serving everybody, decreasing the internet price and increasing the access.

The legal relations of information and communications sector is coordinated by laws “About communications”, “About prohibition of unfair competition”, “About the right of the author and related rights”, “About patent”, “About foreign investment” , package of laws on taxes and other relevant laws.

The introduction of multi-side consumption based on information, communications technology requires a new legal coordination and therefore draft laws “About e-Government”, “E-signature”, “E-agreement” have been developed.

In the economic development of Mongolia this sector has the fastest growth and achieved much success in the area of development of its infrastructure in recent years.

In the framework of renovation of the communication backbone network according to the trend of the world development, establishment of broadband network country-wide, cable transmission system of 2700 kms length, the information and communications network consists of the cable network of 7500 kms length, digital radio line of 2500 kms length leading to the opportunity of raising substantially the quality of information and communications services to the centers of 21 aimags, 40 big sums and settlements. Support of the private sector in the development of the communications infrastructure has lead to good results. Our operator companies installed the cable network 1800 kms long connecting aimags with local areas, the capital city and foreign countries.

Based on the current level of the development of the communications sector of Mongolia, its future need and development trend, by the decision of the Government the network company has been established for the activities to develop the core network of information and communications, creation of equal utilization conditions to service providers.

As a result of the Government policy of deepening the competition in the information and communications sector, now there are 3 mobile phone operators and over 10 internet providers.

As a result of such programs as “Computer to everybody”, “One tugrug internet”, “Internet to every family” aimed at development information and communications education, raising usage of internet, the price of computer and internet services reduced substantially. Since one year implementation of the program over 30 000 families acquired computers. Now over 80 000 families have computers and the number of internet users exceeded 400 000. One year ago it was 70 мб\с, and although this year the international flow of the Mongolian internet is 155 мб\с, it still does not fully meet the rising demand.

It is evident that investment in the information and communications sector of Mongolia is beneficial. Now such joint investment companies of mobile phones such as Mobicom, Skytel, Unitel are successfully operating in Mongolia and are the best examples of investment in Mongolia.

Although the development information and communications sector achieved much success it should be noted that development of certain policy is required. For example, attention should be paid to transfer of Government services to citizens and organizations to the digital form and support of information technology in the education and health sectors. We are ready to support activities and initiatives aimed at resolving these issues and making it possible to make investment beneficial is not denied.

The Government of Mongolia aims at creation and development of program supply, the information technology products and services for international market. Within the framework of this objective the National Information Technology Park has been established for support of the information technology venture business and out-sourcing. The Government decided the policy of supporting this sector and some program supply entities started reaching international market.

Taking this opportunity I would like to note that as a Chairman of the Information and Communications Technology Authority I will cooperate and support the proposals and initiatives for resolving the sector issues.

I am confident that this conference will have important impact for future development of the sector, widening the cooperation of participant parties, finding new partners, new opportunities and new markets.

I wish success to the conference. Thank you for your attention.

ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН ЧУУЛГАН ДЭЭР МХХТГ-ЫН ДАРГА Ч.САЙХАНБИЛЭГИЙН ХЭЛСЭН ҮГ

Хүндэт зочид, төлөөлөгчид өө,

Хатагтай ноёд оо,

Их Монгол Улс байгуулагдсны 800 жилийн ойн арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдаж байгаа хөрөнгө оруулагчдын энэхүү чуулга уулзалтад оролцогч Та бүхний энэ өдрийн амар амгаланг эрж мэндчилье.

Монгол Улсын мэдээлэл, харилцаа холбооны салбарын хөгжлийн өнөөгийн байдал, тус салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримталж бодлого, стратеги, эрх зүйн орчны асуудалд та бүхний анхаарлыг хандуулахыг хүсч байна.

Монгол Улсын Засгийн газраас 800 гаруй жилийн түүхтэй мэдээлэл, харилцаа холбооны салбарын хөгжилд тэргүүлэх ач холбогдол өгч нийгэм, эдийн засгийн хөгжлийг хурдасгагч хүчин зүйл гэж үзэн олон чухал зорилт, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байна.

Мэдээлэл, харилцаа холбооны салбарыг хөгжүүлэх төрийн бодлого нь тус салбарын тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн бодлого, хууль эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх, мэдээлэл, харилцаа холбооны найдвартай дэд бүтцийг бий болгох, хүний нөөцийг бүх талаар хөгжүүлэх, мэдээлэл, харилцаа холбооны технологид суурилсан олон талт хэрэглээг хөгжүүлэх, интернэтийн үйлчилгээний чанар, хүртээмж, хамрах хүрээг өргөжүүлэх, бүх нийтийг компьютержүүлэх, өрх бүрийг интернэтэд холбох хөтөлбөр хэрэгжүүлэх замаар интернэт, компьютер хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэх, иргэд, хөдөлмөрчид, оюутан сурагчдын мэдлэг, мэдээлэл хүртэх, сурч боловсрох боломжийг өргөжүүлэх, бизнес, хувийн секторт дэмжлэг үзүүлэх, түншлэл, хамтын ажиллагааны бүх талын хэлбэр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих, дотоодын програм хангамж, мэдээллийн технологийн үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, гадаад зах зээлд гарах нөхцөл боломжийг бүрдүүлэх, эдийн засгийн хувьд өндөр үр ашигтай салбар болгон хөгжүүлэхэд чиглэгдэж байгаа болно.

Төр засгаас мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарын хөгжлийг эрчимжүүлэх, салбарын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах зорилгоор Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд 2004 онд Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрыг байгуулсны дээр Засгийн газрын 2004-2008 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийгмийн бүх салбарт мэдээлэл, харилцаа холбооны технологийг нэвтрүүлэх чухал бөгөөд өндөр хариуцлагатай зорилтыг тусгасан байгаа болно.

Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газар байгуулагдсан цагаас эхлэн холбогдох хууль тогтоомж болон “Мэдээлэл, холбооны технологийг 2010 он хүртэл хөгжүүлэх үзэл баримтлал”, “Хөдөөгийн холбоог 2021 он

хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөө”, “Цахим Монгол” хөтөлбөрүүдийн хүрээнд салбар дахь либеральчлал, өрсөлдөөнийг гүнзгийрүүлэх, салбарын хөгжлийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох, мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийг хөгжүүлэх, цахим хэрэглээ, түүний дотор цахим Засгийг хөгжүүлэх, тоон ялгааг бууруулах, бүх нийтийн үйлчилгээний эрх зүйн орчинг боловсронгуй болгох, бүх нийтийн мэдээллийн технологийн боловсролыг хөгжүүлэх, интернэтийн үнэ тарифыг бууруулах, хүртээмж, хамраах хүрээг өргөжүүлэх чиглэлээр томоохон ажлуудыг хийж хэрэгжүүлж байна.

Өнөөдөр мэдээлэл, харилцаа холбооны салбарын эрх зүйн харилцаа “Харилцаа холбооны тухай”, “Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай”, “Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай”, “Патентийн тухай” “Гадаадын хөрөнгө оруулалтын тухай” болон татварын багц хууль, холбогдох бусад хууль тогтоож, эрх зүйн актаар зохицуулагдаж байна.

Мэдээлэл, харилцаа холбооны технологид суурилсан олон талт хэрэглээ нийгэмд нэвтэрч байгаа нь эрх зүйн шинэ зохицуулалт шаардаж байгааг харгалзан үзэж “Цахим Засаглалын тухай”, “Цахим гарын үсгийн тухай”, “Цахим хэлцлийн тухай” хуулиудын төслийг боловсруулаад байна.

Монгол Улсын эдийн засгийн хамгийн эрчимтэй хөгжиж буй салбарын нэг болох тус салбар дэд бүтцээ хөгжүүлэх чиглэлээр сүүлийн жилүүдэд амжилт арвинтай ажиллаж байна.

Дэлхийн нийтийн хөгжлийн чиг хандлагын дагуу цахилгаан холбооны үндсэн сүлжээг өртөтгөн шинэчлэх, улс орныг хамарсан өргөн зурвасын сүлжээ байгуулах зорилтын хүрээнд энэ жил 2700 гаруй км урттай шилэн кабелийн дамжуулах байгууламжийг барьж байгуулснаар Монгол Улсын мэдээлэл, харилцаа холбооны суурь сүлжээ 7500 орчим км шилэн кабелийн сүлжээ, 2500 км урт тоон радио релейнээс бүрдэж 21 аймгийн төв, дамжин өнгөрөх 40 гаруй томоохон сум, суурин газруудын мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээнд чанарын томоохон дэвшил гарах нөхцөл, боломж бүрдэж байна. Мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийг хөгжүүлэхэд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжиж ажилласан нь үр дүнгээ өгч манай томоохон оператор компаниуд одоогоор 1000 гаруй км шилэн кабелийн сүлжээ байгуулж, 1800 гаруй км тоон радио релейгээр аймаг орон нутгуудыг өөр хооронд нь болон нийслэл хот, гадаад ертөнцтэй холбож байна.

Монгол Улсын цахилгаан холбооны салбарын хөгжлийн өнөөгийн түвшин, улс орны цаашдын эрэлт хэрэгцээ, хөгжлийн чиг хандлагатай уялдуулан Засгийн газрын шийдвэрээр мэдээлэл, харилцаа холбооны үндсэн сүлжээг эзэмшиж хөгжүүлэх, үйлчилгээ эрхлэгчдэд ашиглалтын ижил тэгш нөхцөл бүрдүүлэх чиг үүрэг бүхий сүлжээний компанийг байгуулж үйл ажиллагааг нь эхлүүлээд байна.

Төр засгаас мэдээлэл, харилцаа холбооны салбар дахь өрсөлдөөнийг гүнзгийрүүлэх бодлого авч хэрэгжүүлсний үр дүнд манай улсад үүрэн

телефоны 3 оператор, интернэтийн үйлчилгээний 10 гаруй байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Бүх нийтийн мэдээллийн технологийн боловсролыг хөгжүүлэх, интернэтийн хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй Засгийн газрын “Бүх нийтийн компьютержүүлэлт”, “Нэг төгрөгний интернэт”, “Өрх бүрт интернэт” хөтөлбөрүүдийн үр дүнд компьютер, интернэтийн үйлчилгээний үнэ тариф мэдэгдэхүйц буурч хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойшхи жил гаруйн хугацаанд 30 000 гаруй айл өрх шинээр компьютертэй болж компьютертэй өрхийн тоо 80 000, нийт интернэт хэрэглэгчдийн тоо 400 000 хол давж, жил гаруйн өмнө 70 Мб/с байсан монголын интернэтийн олон улсын урсгал өнөө жил 155 Мб/с болсон хэдий ч өнөөгийн өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг бүрэн хангахгүй байна.

Монгол Улсын мэдээлэл, харилцаа холбооны салбар хөрөнгө оруулалтын үр ашигтай салбар гэдгээ харуулж чадсан юм. Одоогийн байдлаар хамтарсан хөрөнгө оруулалттай үүрэн телефоны Мобиком, Скайтель, Юнител компаниуд Монгол Улсын зах зээл дээр үйл ажиллагаагаа амжилттай явуулж хөрөнгө оруулалтын шилдэг үлгэр жишээ болж байна.

Монгол Улсын мэдээлэл, харилцаа холбооны салбар эрчимтэй хөгжиж ахиц дэвшил гарч байгаа ч цаашид зохих ёсоор анхаарч тодорхой бодлого боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай зүйл байдгийг тэмдэглэн хэлэх нь зүйтэй гэж үзэж байна. Тухайлбал, иргэд, байгууллагуудад чиглэсэн төр засгийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, боловсрол, эрүүл мэндийн салбарыг мэдээллийн технологиор дэмжих асуудал хоцрогдож байгаа болно. Улс орны өмнө тулгараад байгаа эдгээр асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн аливаа үйл ажиллагаа, санал санаачилгыг бид дэмжин ажиллахад бэлэн ба хөрөнгө оруулалтын үр ашигтай талбар болж болохыг үгүйсгэхгүй байна.

Монгол Улсын Засгийн газраас програм хангамж, гадаад зах зээлд чиглэсэн мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болгож хөгжүүлэхийг зорьж байна. Энэ зорилтын хүрээнд мэдээллийн технологийн венчер бизнесийг дэмжих, аутсорсинг хөгжүүлэх зорилго бүхий Мэдээллийн технологийн үндэсний паркыг байгуулан үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Төр засгаас энэ салбарыг хөгжүүлэх бодлогын үр дүн гарч программ хангамжийн зарим аж ахуйн нэгжүүд гадаад зах зээл гарах гараагаа эхлээд байна.

Монгол Улсын мэдээлэл, харилцаа холбооны салбарын асуудал хариуцсан агентлагын тэргүүний хувьд салбарын өмнө тулгарсан аливаа асуудлыг шийдвэрлэх санал санаачилгыг дэмжиж хамтран ажиллахад бэлэн гэдгээ энэ завшааныг ашиглан хэлэхийг хүсч байна.

Энэхүү чуулган манай салбарыг цаашид хөгжүүлэх, оролцогч талууд хамтын ажиллагаа өргөжүүлэх, шинэ түнш, шинэ боломж, шинэ зах зээл олоход чухал ач холбогдолтой алхам болно гэдэгт итгэж байна.

Чуулганы ажиллагаанд амжилт хүсье.
Анхаарал тавьсан явдалд их баярлалаа.